

**“ДДЭШ ТВ” ХХК-ИЙН ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ
НӨХЦӨЛ /RAO/**

Энэхүү баримт бичгээр Телевизийн үйлчилгээ эрхлэгчтэй байгуулах харилцан холболтын гэрээний ерөнхий нөхцөлийг тодорхойлсон ба Харилцаа Холбооны Зохицуулах Хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх)-ны 2021 оны 33 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох, гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам” (цаашид “Холболтын журам” гэх)-ын 2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсэгт заасныг баримтлан боловсруулсан болно.

“ДДэш ТВ” ХХК нь олон суваг дамжуулах үйлчилгээг **13300002** тоот тусгай зөвшөөрөлтэйгээр Монгол улсын нутаг дэвсгэрт Телевиз, радиогийн олон сувгийг хиймэл дагуулаар дамжуулах үйлчилгээг эрхлэн хүргэдэг, Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч компани болно.

Нэг. Сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлага

1.1 Телевизийн студиэс өгөх дохио нь дараах стандарт, үзүүлэлтийг хангана.

a. **ИНТЕРФЕЙС**

| | |
|---------------|--|
| Дурсний оролт | SMPTE 259M (SD-SDI) <i>/харин HD форматаар дамжуулах бол SMPTE 292M (HD-SDI)/</i> |
| Дууны оролт | Embedded audio (Дурсний сигналд нь суулгасан аудио сигнал) |

b. **ДҮРСНИЙ ҮЗҮҮЛЭЛТ**

| | |
|----------------------------|---|
| Дурсний харьцаа | 4:3 /харин HD форматаар дамжуулах бол 16:9/ |
| SD нягтрал болон фреймрейт | 576i@25 |
| HD нягтрал болон фреймрейт | 1080i@25 |

c. **ДУУНЫ ҮЗҮҮЛЭЛТ**

| | |
|--------------|---------------|
| Дууны коддол | Стерео хос |
| Дууны түвшин | -18dbFs (0db) |

1.2 “ДДэш ТВ” ХХК нь Телевизийн хөтөлбөрийг дараах стандартын дагуу Монгол улсын нутаг дэвсгэрт хиймэл дагуулын сүлжээгээр дамжуулан хэрэглэгчдэд хүргэнэ.

A. **ДҮРСНИЙ ҮЗҮҮЛЭЛТ**

| | |
|--|--|
| Дурсний шахалт болон битрейт H.264 4:2:0 кодлуур | |
| MPEG-4 MP@ML | SD 0.3 to 5 Mbps (VBR) /HD 0.3 to 15 Mbps (VBR)/ |
| Дурсний харьцаа | SD 4:3 /HD16:9/ |

B. **ДУУНЫ ҮЗҮҮЛЭЛТ**

| | |
|--------------|---------------------------------|
| Дууны формат | MPEG-1 Layer I, MPEG-1 Layer II |
| Дууны коддол | Stereo |

Хоёр. Зааглах цэгийн байршил, ашиглалт үйлчилгээ


2.1 Сүлжээнд холбогдох зааглах цэгийн байршилыг болон тоног төхөөрөмжийн мэдээллийг дараах хүснэгтэд харуулав.

| Зааглах цэг | Байршил |
|------------------------|--|
| Зааглах цэгийн байршил | Хаяг: УБ хот, СХД, 34-р хороо, ДДЭШ Газрын станц, 1 давхар |
| Тоног төхөөрөмж | №6 FDF байна |

2.2 Зааглах цэгийн холболтын зураглалын дагуу шилэн кабель түрээслэх болон түүний ашиглалт үйлчилгээг “ДДэш ТВ” ХХК нь хариуцан ажиллаж тухайн сард гарах түрээс ашиглалтын зардлыг тус бүр телевиз талаас авч, тусгай зөвшөөрөл бүхий гуравдагч компанийд гэрээний дагуу дамжуулан төлнө.

2.3 Зааглах цэгийг дээрх байршилаас өөр цэгт тогтоох боломжгүй.

2.4 Холболтын схем, зураглал.



Гурав. Гэрээ хийх үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл, холбогдох ажилтнуудын мэдээлэл

| № | Холбогдох харилцаа | Нэр, албан тушаал | Утас, и-мэйл |
|----|--|---|---|
| 1. | Гэрээтэй холбоотой харилцаанд: | Э.Мөнгөнзүл Ахлах контент продюсер | Утас: 89111087, mungunzule@ddishtv.mn |
| 2. | Ашиглалт үйлчилгээ, дамжуулалтай холбоотой харилцаанд: | Ц.Цэдэнсодном Үндсэн систем ашиглалтийн хэлтсийн менежер | Утас: 88116444, tsedensodnom.ts@ddishtv.mn |
| 3. | Санхүү, төлбөр тооцоотой холбоотой харилцаанд: | Н.Отгонзаяа Нягтлан бодогч | Утас: 89118786, otgonzaya.n@ddishtv.mn |
| 4. | Маркетингтай холбоотой харилцаанд: | Г.Тэнгис Маркетингийн мэргээсилтэн | Утас: 80107347, tengis.g@ddishtv.mn |

Дөрөв. Сар бүрийн суваг дамжуулалтын төлбөр, анхны холболтын хураамж

1. Анхны холболтын төлбөр зааглах цэгийн байршилаас үл хамааран доорх хүснэгтийн дагуу байна.

| № | Хураамжийн нэрс | Давтамж | Төлбөр |
|---|------------------------------------|---------|--------|
| 1 | Сүлжээнд холбогдох хураамж | 1 удаа | ...₮ |
| 2 | Төхөөрөмж | 1 удаа | ...₮ |
| 3 | SD-гээс HD болох холболтын хураамж | 1 удаа | ...₮ |

2. Сар бүрийн суваг дамжуулалтын төлбөр

| № | Зардлын нэр төрөл | Холболтын төрөл | Суваг дамжуулалтын зардал ₮ | |
|---|-----------------------|-----------------|-----------------------------|------------|
| | | | УБ хот | Орон нутаг |
| 1 | Шилэн кабелийн түрээс | SD | ...₮ | ...₮ |

*Уг зардалд НӨАТ багтаагүй болно.

Тайлбар:

“Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ын 2.9-д зааснаар дээрх төлбөрийн хэмжээг тогтоохдоо бизнесийн аливаа алдагдлыг нөхөх зорилго агуулахгүй байх зарчмыг баримтлана.

Жич: Телевиз нь зааглах цэг хүртэл татсан гуравдагч этгээдэд төлөх шилэн кабелийн түрээсийн төлбөр, шилэн кабелийн ашиглалт үйлчилгээний зардлыг тухайн сарын 5-ны дотор “ДДЭШ ТВ” ХХК-ийн Хаан банкны 5174005550 тоот /төгрөгийн/ дансанд Сүлжээнд холбогдох гэрээнд заасны дагуу шилжүүлэх бөгөөд талууд төлбөр барагдуулсан актыг сар бүр хоёр талаас харилцан баталгаажуулж явна.

СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ ГЭРЭЭ

20.... оны ... дугаар сарын ... өдөр

№

Улаанбаатар хот

Монгол Улсын Иргэний хууль болон Харилцаа холбооны тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн холбогдох зүйл заалт, “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох, гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”, “ДДэш ТВ” ХХК-ийн олон суваг дамжуулах үйлчилгээний сүлжээнд холбогдох нөхцөл /RAO/-ыг тус тус удирдлага болгон Хиймэл дагуулаар телевизийн хөтөлбөрийг Монгол улсын нутаг дэвсгэрт дамжуулах тухай энэхүү гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Нэг талаас, Улсын бүртгэлийн албанад 5195756 тоот регистрийн дугаарт бүртгүүлсэн, “ДДэш ТВ” ХХК (цаашид “Дамжуулагч” тал гэх),

Нэгээ талаас тоот регистрийн дугаартай “.....” ХХК (цаашид “Нийлүүлэгч” тал гэх) (хамтад нь “Галууд” гэх) харилцан тохиолцож, зөвшөөрснөөр байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү гэрээгээр Дамжуулагч тал нь Нийлүүлэгч талын телевизийн хөтөлбөрийг өөрийн сувгийн ... дугаарлалт дээр байршуулан, Монгол орон даяар сансрын хиймэл дагуулаар дамжуулах үйлчилгээг тасралтгүй, найдвартай дамжуулан өөрийн хэрэглэгчдэд хүргэх, нийлүүлэгч нь холболтын зардал, суваг дамжуулагдах шилэн кабелийн түрээс түүнтэй холбоотойгоор гарах ашиглалт үйлчилгээний зардлыг дамжуулагч талд төлөхтэй холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү гэрээ нь Талуудын үүсгэн байгуулагч/хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирад нь өөрчлөгдсөнөөс үл хамааран үйлчлэх хугацааны туршид хүчин төгөлдөр байна.
- 1.3 Энэхүү гэрээг 20... оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн нийлүүлэгч талын тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаатай ижил байна.
- 1.4 Энэхүү гэрээний хавсралтууд нь гэрээний салшгүй нэгэн хэсэг болно.

ХОЁР. ДАМЖУУЛАГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

Дамжуулагч тал нь дараах эрхийг эдэлнэ:

- ~ 2.1.1 Гэрээний 1.1-т заасан суваг дамжуулах үйлчилгээг үзүүлж буй хугацаанд хамаарах зардлыг төлөхийг телевизээс шаардах;
- 2.1.2 Нийлүүлэгчээс хамаарсан гэмтэл, саатлын улмаас эфирийг тасалдуулсан тохиолдолд дамжуулагч нь энэ талаар хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх;
- 2.1.3 Дамжуулагч тал үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардагдах нийлүүлэгч талын гаргаж өгсөн бичиг баримт, мэдээлэл болон тоног төхөөрөмж нь шаардлага хангахгүй тохиолдолд доголдолыг арилгахыг шаардах;
- 2.1.4 Дамжуулагч талын албан ёсны эрхтэй аливаа контентыг зохих зөвшөөрөлгүйгээр өөрийн сувгаар гаргахгүй байхыг болон гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлэхийг нийлүүлэгчээс шаардах;
- 2.1.5 Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу дамжуулалтын зардлыг хугацаандаа төлөөгүй тохиолдолд гэрээний 1.1-д заасан сувгийн дугаарлалтанд өөрчлөлт оруулах, эсхүл төлбөрөө төлж барагдуулах хүртэл дамжуулалтыг зогсох;
- 2.1.6 Зохиогчийн эрхийн тухай хуулийн 52.1-т заасны дагуу “Энэ хуулийн 52.1-т заасан этгээд нь зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийн эрх зөрчигдэж байгаа тухай мэдээллийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх, зөрчлийн тухай мэдсэн дариу тухайн зөрчилтэй бүтээл, хамаарах эрхийн объект ашиглалтыг зогсох, хаах үүрэг хүлээнэ” гэж заасны дагуу нийлүүлэгч тал оюуны өмчийн зөрчил гаргасан тохиолдолд дамжуулагч тал сувгийн эфирийг хаах хүртэл арга хэмжээг авах;
- 2.1.7 Нийлүүлэгч талын буруутай үйл ажиллагааны улмаас болон гэрээний дагуу дамжуулалтын зардлыг төлөөгүйн улмаас дамжуулагч талд хохирол учирсан тохиолдолд хохирлоо нөхөн төлүүлэх;
- 2.1.8 Байгалийн гамшиг, олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, халдварт өвчин гарах, онц ноцтой гал түймэр дэгдэх, дайны болон онц байдал зарлах, зэрэг гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл тохиолдсны улмаас эрх бүхий байгууллагын үүрэг болгосны дагуу нийлүүлэгч талын ямар ч нэвтрүүлгийн дундуур тухайн байдлын талаар олон нийтэд мэдээлэл хийх эрхтэй;
- 2.1.9 Хуульд заасан бусад эрх;
- 2.2 Дамжуулагч тал дараах үүргийг хүлээнэ:

- 2.2.1 Дамжуулагч тал нь нийлүүлэгч талын нэвтрүүлгийг ямар нэг техникийн саад учруулалгүйгээр нэвтрүүлэх үүднээс ажил үүргийг зохих мэргэжлийн ур чадвар бүхий хүмүүсээр хийж гүйцэтгүүлэх;
- 2.2.2 Сансын хиймэл дагуул ашиглан телевизийн олон сувгийн хөтөлбөр дамжуулах Үйлчилгээг гэрээний хугацаанд чанартай, тогтвортой явуулж, телевизийг өөрийн багцуудад оруулан Монгол орон даяар өөрийн хэрэглэгчдэд дамжуулсан хүргэх;
- 2.2.3 Нийлүүлэгч тал оюуны өмчийн албан ёсны эрхтэй контентыг зөвшөөрөлгүй дамжуулсан тохиолдолд дамжуулагч тал зөрчлийг арилгах талаар Нийлүүлэгч талд мэдэгдэх;
- 2.2.4 Өөрийн техник, технологийг тоон системийн DVB-S2 стандарт болон олон улсын цахилгаан холбооны байгууллагын стандартын шаардлагыг бүрэн хангаж ажиллах;

ГУРАВ. НИЙЛҮҮЛЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Нийлүүлэгч тал нь дараах эрхийг эдлнэ:
 - 3.1.1 Дамжуулагч талын үзүүлж буй үйлчилгээ болон хийгдэж буй ажлууд нь чанарын шаардлага хангахгүй байвал шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгуулах;
 - 3.1.2 Гэрээндээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн зөвхөн зохих өсөөр буюу шударгаар биелүүлэхийн нөгөө талаардах;
 - 3.1.3 Техник, тоног төхөөрөмжид үзлэг шалгалт хийх зэргээр эфирийг зайлшгүй шаардлагаар хааж болно;
 - 3.1.4 Гэрээнд заасан нөхцөлийн дагуу гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээний хугацааг сунгах тухай санал гаргах;
 - 3.1.5 Сүлжээний найдвартай, тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлыг бүрэн хангахыг дамжуулагчаас шаардах эрхтэй;
 - 3.1.6 Хуульд заасан бусад эрх;
- 3.2 Нийлүүлэгч тал нь дараах үүргийг хүлээнэ:
 - 3.2.1 Хөтөлбөрийн дуу дүрсний дохиог дамжуулагч талын шаардсан техникийн нөхцлийг дагаж мөрдөх.
 - 3.2.2 Дамжуулагч талаас өгсөн техникийн нөхцөл, шаардлагыг хангах техник тоног төхөөрөмжийнхөө хэвийн найдвартай ажиллагааг гэрээний хугацаанд тогтвортой хангаж ажиллах;
 - 3.2.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхэд шаардагдах бусад тусгай зөвшөөрөл, лицензийг зохих журмын дагуу цаг тухайд нь эрх бүхий байгууллагаас авч, хүчин төгөлдөр байдлыг нь гэрээний хугацаанд хэвээр хадгалах;
 - 3.2.4 Гэрээнд заасан зардлыг дамжуулагч талд хугацаандаа төлж байх;
 - 3.2.5 Нийлүүлэгч тал телевизийн нэвтрүүлгийн хөтөлбөрийнхөө цагийн хуваарийг гурав хоногийн өмнө дамжуулагч талд epg@ddishtv.mn хаягаар тогтмол мэдэгдэх;
 - 3.2.6 Дамжуулагч талын албан ёсны эрхтэй аливаа контентыг зохих зөвшөөрөлгүйгээр өөрийн сувгаар гаргахгүй байх;
 - 3.2.7 Дамжуулагчаас хамааралгүйгээр аливаа техникийн саатал гарсны улмаас суваг гарахгүй болсон тохиолдолд Нийлүүлэгч нь “МАНАЙ СУВГИЙН ТЕХНИКТЭЙ ХОЛБООТОЙ ЭФИРИЙН СААТАЛ ГАРСАН ТУЛ ХҮЛЦЭЛ ӨЧЬЕ” гэсэн утга, агуулгатай мэдэгдлийг өөрийн сувгийн дэлгэц дээр байршуулах;
 - 3.2.8 Тоног төхөөрөмжтэй холбоотой өөрчлөлт, түр зогсолт, техникийн шинэчлэл хийгдэх, байршил солих гэх мэт зорилгоор эфирээ таслах буюу зайлшгүй зогсолт хийх тохиолдолд 7 хоногийн өмнө дамжуулагч талд бичгээр болон мэйлээр урьдчилан мэдэгдэх;

ДӨРӨВ. ТӨЛБӨР ТООЦОО

- 4.1 Нийлүүлэгчийн хөтөлбөрийг хүлээн авч өөрийн тоног төхөөрөмж рүү дамжуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, анхны удаа холбох зардлыг Нийлүүлэгч тал 100% өөрийн хөрөнгөөр шийдвэрлэнэ.
- 4.2 Нийлүүлэгч нь өөрийн эфирээ дамжуулагч талын хиймэл дагуулаар Монгол орон даяар SD болон HD форматаар сонгон дамжуулж болох бөгөөд хэрэв Нийлүүлэгч тал нь HD форматаар дамжуулалт сонгосон тохиолдолд нэмэлт төлбөр сар бүр төлнө. Жич: Нэмэлт төлбөрийн хавсралтаар тусгайлан тогтооно.
- 4.3 Талууд харилцан тохиролцож шилэн кабелийн түрээсийн төлбөрийн хэмжээг хавсралтаар тусгайлан тогтооно.
- 4.4 Нийлүүлэгч нь гэрээний 4.3-д заасан зардлыг дамжуулагч талд сар бүрийн 05-ны дотор нэхэмжлэхийн дагуу дамжуулагчийн Хаан банкны 5174005550 тоот /төгрөгийн/ дансанд шилжүүлнэ.
- 4.5 Талууд дамжуулалтын форматыг харилцан тохиолцож, гэрээний хавсралтын дагуу шийдвэрлэнэ.

ТАВ. АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ, ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

- 5.1. Дамжуулагч тал нь нийлүүлэгч талын телевизийн нэвтрүүлгийн 24 цагийн турш хиймэл дагуулаар, тасралтгүй цацах үйлчилгээг үзүүлэх ба ингэхдээ хоёр талын харилцан тохиролцсоноос бусдаар дээрх хугацааг тасалдуулахгүй.
- 5.2. Дамжуулагч тал нь тоног төхөөрөмждөө үзлэг, үйлчилгээг хийх зорилгоор техникийн бүрэн зогсoltыг улиралд 1 удаа 00:00 цагаас 06:00 цагийн хооронд хийж байх бөгөөд энэ хугацаанд нийлүүлэгч талын нэвтрүүлгийг дамжуулахгүй.
- 5.3. Харилцан холболтын нөхцөлд заасан зааглах цэгт байршуулсан нийлүүлэгч талын тоног төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээг дамжуулагч тал хариуцан ажиллах бөгөөд уг төхөөрөмжид техникийн горим алдагдсан буюу дамжуулагч тал нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас эвдэрч гэмтсэнээс бусад байдлаар гарсан тохиолдолд дамжуулагч тал түүнийг хариуцахгүй.
- 5.4. Дамжуулагч тал нь сар бүр нэвтрүүлгийн дуу дүрсний чанарын нэгдсэн үнэлгээг хийх ба мөн нийлүүлэгч тал нь өөрийн талаас хэмжилт хийх нөхцлийг бүрдүүлиэ. Нийлүүлэгч талын дуу дүрсний чанар, техникийн норм болон стандартад нийцэхгүй байгааг Харилцаа Холбооны Зохицуулах Хороондоо мэдээлж өргөн хэмжээ авахын сануулсан тохиолдолд дамжуулагч нь дамжуулалтад зогсоо хүртэл арга хэмжээ авна.
- 5.5. Үйлчилгээг хэвийн, чанартай, тасралтгүй явуулахын тулд шаардлагатай мэдээллүүдийг талууд харилцан солилцох бөгөөд солилцож буй мэдээллийн нууцлалыг хамгаална.

ЗУРГАА. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

- 6.1 Харилцан холболт хийх техникийн үзүүлэлтийн талаарх зохицуулалт,
 - 6.1.1 Талуудын холболтын болон дамжуулах байгууламжийн төрөл марк, интерфейсууд, харилцан холбогдоход шаардагдах бусад техник төхөөрөмж, багтаамж, тоо ширхэг зэрэг нь RAO-д заасны дагуу байна. RAO-д орсон нэмэлт өөрчлөлтүүдийг тухай бүр албан бичгээр мэдэгдэнэ.
 - 6.1.2 Сүлжээ хоорондын дамжуулах видео сигнал нь стандартыг хангасан байх ба энэ нь хэрэглэгчид рүү дуу дүрсний чанар хангасан өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрийг дамжуулах нөхцөлийг бүрдүүлиэ.
 - 6.1.3 Талуудын харилцан холболтын шугам нь өндөр хурдны оптик сүлжээ байна.
- 6.2 Зааглах цэгийн талаарх зохицуулалт,
 - 6.2.1 Сүлжээний зааглах цэгүүдийн байршил RAO-д заасны дагуу байна.
 - 6.2.2 Зааглах цэг дэх техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг гэрээнд заасны дагуу хариуцна.
 - 6.2.3 Сүлжээ хоорондын харилцан холболтын зураглал нь RAO-д заасны дагуу байна.
- 6.3 Сүлжээний ачааллын талаарх зохицуулалт,
 - 6.3.1 Харилцан холболтын техникууд /хувиргах, дамжуулах төхөөрөмжүүд болон сигнал дамжуулах бүх төрлийн кабелиуд/-ийн найдвартай ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг ханган ажиллана.
 - 6.3.2 Нийлүүлэгч талаас эфирийн гаралтын дуу дүрсний форматаа өөрчлөх /техникийн өөрчлөлт болон шинэчлэлт хийх/ тохиолдолд 7 хоногийн өмнө урьдчилан дамжуулагчид мэдэгдэн харилцан тест хийж талууд сувгийн үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах тал дээр хамтран ажиллана.
 - 6.3.3 Харилцан холболтын гэрээний хугацаанд хийгдэх техник тоног төхөөрөмжийн өргөтгөл, өөрчлөлт нь харилцан холбогдогч талуудын үйлчилгээнд нөлөөлөхүйц байвал энэ талаарх мэдээллийг 72 цагаас доошгүй хугацааны өмнө нөгөө талдаа мэдэгдэх ба асуудлыг талууд хамтран шийдвэрлэнэ.

ДОЛОО. ОЮУНЫ ӨМЧИЙН ХАРИЛЦАА

- 7.1 Нийлүүлэгч талын албан ёсны логог дамжуулагч тал дамжуулахдаа түүний хэлбэр дүрс, өнгө зэрэгт ямар нэг байдлаар өөрчлөлт оруулалгүйгээр дамжуулна.

СУВГИЙН ЛОГО

- 7.2 Нийлүүлэгч тал нь өөрийн албан ёсны логог дамжуулагч талд marketing@ddishtv.mn хаягаар цахим байдлаар өгнө.
- 7.3 Өргөн нэвтрүүлгийн телевизийн хөтөлбөр бэлтгэх, хүргэх үйл ажиллагаанд оюуны өмчийг дээдлэх, оюуны өмчийн зөрчилтэй талууд хамтран тэмцэнэ.
- 7.4 Нийлүүлэгч талын албан ёсны логог дамжуулагч тал нь өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээний сурталчилгаанд (тухайлбал телевизийн олон суваг дамжуулах үндсэн үйлчилгээний танилцуулга, сурталчилгаанд телевизийн сувгуудыг дурдах зэрэгт) ашиглах эрхтэй бөгөөд ингэхдээ түүний хэлбэр дүрс, өнгө зэрэгт ямар нэг байдлаар өөрчлөлт оруулахгүйгээр ашиглана.

7.5 Дамжуулагч талын албан ёсны эрхтэй контентыг дахин дамжуулж буй эсэхийг хянах зорилгоор нийлүүлэгч тал нь өөрийн дамжуулж буй телевизийн хөтөлбөр дээр өөрийн логог тунгалаг байдлаар болон таних тэмдэг, тэмдэгтүүдийг байрлуулж хянах бөгөөд ингэхдээ нийлүүлэгч талын логог дараахгүй байна.

НАЙМ. ХАРИУЦЛАГА, ХАРИУЦЛАГААС ЧӨЛӨӨЛӨГДӨХ ҮНДЭСЛЭЛ

- 8.1 Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй талын буруугаас нөгөө талд хохирол учирсан тохиолдолд юуны өмнө хохирсон тал өөрийн хохирлын хэмжээг нотлох үүрэгтэй бөгөөд буруутай тал нь нөгөө талд учирсан хохирлыг энэ гэрээ болон хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлнэ.
- 8.2 Нийлүүлэгч нь дамжуулагчийн тоног төхөөрөмжөөр дамжин хэрэглэгчдэд очиж байгаа өөрийн контентын чанар, стандартад хяналт тавих, зохиогчийн эрхээр хамгаалагдсан телевизийн нэвтрүүлэг, дуу, дүрс, кино зэргийг зохих зөвшөөрөлгүйгээр нэвтрүүлсэнтэй холбоотой хариуцлагаыг бүрэн хүлээнэ.
- 8.3 Байгалийн гамшиг, хиймэл дагуулын үйл ажиллагааны доголдол, хүчтэй салхи дэгдсэн, их хэмжээний хур тунадас орсон болон нарны нөлөө орсон олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, халдварт өвчин гарах, онц тоитой тал түүмжэр үзүүлэх, дайны болон онц байдал ширлах, зөргөн тэнэгийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүгдийг, эсхүл аль нэгийг нь биелүүлээгүй бол ийнхүү биелүүлээгүйн улмаас гарах үр дагаварт талууд хариуцлага хүлээхгүй.
- 8.4 Нийлүүлэгчийн эфирээр цацгадж буй мэдээ, мэдээлэл болон контентын өмнөөс болон Нийлүүлэгч тал гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас эфир хаагдсанаас хамаарсан аливаа хохиролд дамжуулагч нь хариуцлага хүлээхгүй.
- 8.5 Гэрээний хугацаа дуусгавар болсон гэрээг цуцалсан тохиолдолд дамжуулагч тал нь нийлүүлэгчийн хөтөлбөрийг дамжуулахаас татгалзах бөгөөд энэ тохиолдолд Нийлүүлэгч нь 4.3-т заасан төлбөрийг дамжуулагч талд төлөх үүргээс чөлөөлөгдөхгүй.

ЕС. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ ЦУЦЛАХ

- 9.1 Гэрээний талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй эсвэл удаа дараа биелүүлээгүй тохиолдолд нөгөө талдаа гэрээний үүргээ биелүүлэхийг шаардсан албан бичиг хүргүүлэх бөгөөд хүргүүлснээс хойш ажлын 5 хоногийн дотор тухайн гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө талдаа гэрээг цуцлах тухай санал гаргаж болох ба уг саналыг бичгээр гаргана.
- 9.2 Талууд харилцан хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр гэрээг цуцалж болно.
 - 9.2.1 Давагдашгүй хүчин зүйлс тохиолдсон;
 - 9.2.2 Гэрээнд оролцогч тал цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон болон дампуурснаа албан ёсоор зарласан;
 - 9.2.3 Гэрээнд оролцогч тал шилэн кабелийн төлбөрөө төлөөгүй гэрээнд тохиролцсон боломжит хугацаанаас 3 сараар хэтрүүлсэн;
 - 9.2.4 Гэрээгээр тохиролцсон техникийн үзлэг, шалгалт хийсэн ;
- 9.3 Гэрээ цуцлах санал гаргаснаас ажлын 5 хоногийн дотор нөгөө талаас ямар нэг хариу өгөөгүй тохиолдолд гэрээ цуцлагдсанд тооцно.
- 9.4 Энэхүү гэрээг цуцалсантай холбоотойгоор талуудын өглөг авлагын төлбөр тооцоог буруутай тал нь нөгөө талдаа төлж барагдуулна.

АРАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 10.1. Энэхүү гэрээний үүргийн биелэлттэй холбогдон үүссэн аливаа маргааныг дор дурдсанаар шийдвэрлэнэ:
 - 10.1.1 Маргааны талаар нөгөө талд бичгээр хандаж мэдэгдэл гаргана. Талууд уг маргааныг аль болох хоорондоо эв зүйгээр харилцан тохиролцож, зөвшилцлийн журмаар шийдвэрлэнэ;
 - 10.1.2 Хэрэв талууд харилцан тохиролцож чадаагүй тохиолдолд маргаанаа Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 10.2 Энэхүү гэрээтэй холбогдсон аливаа маргаантай асуудлыг хянан шийдвэрлэхэд Монгол улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ.

АРВАН НЭГ. БУСАД ЗҮЙЛ

- 11.1 Гэрээг хоёр хувь үйлдэж баталгаажуулах бөгөөд хувиуд хууль зүйн адил хүчинтэй байна.
- 11.2 Гэрээний хэрэгжилттэй уялдуулан талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тохиолдолд түүнд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулна.
- 11.3 Гэрээний хавсралт болон нэмэлтээр талуудын тохиролцсоны дагуу бусад зүйлийг нарийвчлан тодорхойлж, бусад нөхцөлийг тусгаж өгнө.

11.4 Талууд шүүх болон бусад эрх бүхий байгууллагаас шаардсанаас бусад тохиолдолд энэхүү гэрээ болон түүнтэй холбогдох бичиг баримтын нууцлалыг чандлан хадгална.

АРВАН ХОЁР.ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ

Дамжуулагч тал:

“ДДЭШ ТВ” ХХК

Сүхбаатар дүүрэг, 8-р хороо

Сэнтрал Тауэр 14-р давхар

Утас: 77770101

Факс: 77770202

Нийлүүлэгч тал:

“.....” ХХК

.....

.....

Утас:

Факс:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ДАМЖУУЛАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

НИЙЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Г.БОЛД

БИЗНЕС ХӨГЖИЛ, ТӨЛӨВЛӨЛТИЙН
АЛБАНЫ ЗАХИРАЛ

.....

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Э.БАДАМГАРАВ